

МЭДЛЭГИЙН ТАЛААРХ Ж-Ф.ЛИОТАРЫН ФИЛОСОФИ ҮЗЛИЙН ТУХАЙД

Б.Дагзмаа - МУИС, НШУС, Философийн тэнхим, доктор
Ц.Нямсүрэн - ЭМШУИС, НЭМС, НХУТэнхим, магистр

Түлхүүр үг: Постмодерн нөхцөл, дискурс, хүүрнэл, нарратив мэдлэг, хэлний тоглоом, денотатив хэллэг, прескриптив хэллэг

Товч утга: Постмодерн хэмээх эрин үе ил тодорхой болохын хирээр мэдлэгийн байр байдал өөрчлөгдөж, түүнийг зөвхөн шинжлэх ухааны мэдлэгээр төлөөлүүлэн ойлгох нь өрөөсгөл болж, уламжлалт мэдлэг тэр дундаа нарратив мэдлэгийг өөрөөр үнэлэх нөхцөл бүрдэж байна. Мэдлэг нь дан ганц үнэний шалгуураар хэмжигдэхгүй, бас үйл ажиллагааны өргөн хүрээг хамарсан шалгуур, хэрэгцээнд нийцсэн сайн гүйцэтгэлийг бий болгогч хэмээн тооцогдож, нарратив мэдлэгийг хоцрогдсон, бүдүүлэг, санаанаасаа зохиосон худал зүйл гэж үнэлэх үе үеэ өнгөрөөн, харин нийгэмд өөрийн гэх зэрэг хэрэглээ бүхий, шинжлэх ухааны мэдлэгээс илүү биш юмаа гэхэд дутуугүй байр суурьтайг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй болж байна.

Энэхүү өгүүллийг “Философи: онол, практик” сэдэвт олон улсын хуралд тавьсан “Постмодерн төлөв дэх мэдлэгийн үнэлэмж” хэмээх илтгэлийн өргөтгөл болгон, нийгэм аж үйлдвэржсэний дараах²⁹ эринд шилжихийн хэрээр мэдлэг, түүнийг үнэлэх үнэлэмж хэрхэн өөрчлөгдөж байгааг тайлбарласан Ж.Лиотарын үзлийг танилцуулах зорилгоор бичлээ.

Орчин үеийн шинжлэх ухаан болон мэдлэг, мэдээллийн асуудлаарх асар их материалд хийсэн дүн шинжилгээгээрээ Ж.Лиотар бие биетэйгээ огтолцон зөрчилддөг янз бүрийн сэдэв, янз бүрийн бүтээлийн нэгэн төрөл уулзварыг бүтээсэн юм. Томас Кун, Пол Фейрабенд зэрэг онолчдын анхлан хөгжүүлсэн шинжлэх ухааны судалгаа, түүний парадигмын талаарх шинэ үзлийн хожмын үр дагаварыг хэлэлцсэн Лиотарын хандлага “хуульчлалын хямрал”-ын талаарх Юрген Хабермасын үзэл баримтлал, “шуугиангүй”, “тунгалаг”, бүрэн харилцаатай нийгмийн талаарх төсөөлөлтэй зөрчилддөг.

Шинжлэх ухааны мэдлэгийг өгүүлэмжийн нэгэн төрөл гэж үзсэн тэрээр тэргүүний шинжлэх ухаан, технологиуд 1940-өөд оноос хойшхэлтэй илүү холбоотой хөгжсөнийг тэмдэглээд, энэ өөрчлөлт нь мэдлэгийн амин чухал хоёр функци болох судалгаа, мэдлэгийг дамжуулах үйлийг эрс өөрчлөгдөж байгааг онцолжээ. Мэдээллийн технологиос үүдэлтэй эдгээр өөрчлөлт мэдлэгийг мэдээллийн нэгжид³⁰ хөрвөгдсөн нөхцөлд л үйлдэлт шинжтэй байх нөхцөл бүрдүүлж, хөгжиж байгаа хийгээд хөгжсөн улс орнуудын зөрөө ирээдүйд улам нэмэгдэхэд хүргэж байна. Түүний үзсэнээр мэдээллэн барааны хэлбэрээрээ мэдлэг нь эрх мэдлийн төлөөх дэлхий нийтийн тэмцэлд хамгийн чухал бооцоо болж, төрт улсууд мэдээллийг хянахын төлөө тэмцэлдэнэ. Мэдлэг нь нийгмийн

²⁹ Bell D. The Coming of Post-Industrial Society. New York, 1973 ; Hassan I. The Dismemberment of Orpheus : Toward a Post Modern Literature. New York : Oxford U.P., 1971 ; Benamou M & Caramello Ch. (ed.) Performance in Post Modern Culture. Wisconsin : Center for XXth Century Studies & Coda Press, 1977.

³⁰ Мэдээллийн нэгж нь бит юм. Мэдээг тоон кодаар бичих нь тухайлбал хоёрдмол утгаас зайлсхийх боломж олгодог. Watzlawick P., Helmick-Beavin J., Jackson D. Pragmatics of Human Communication. A Study of International Patterns, Pathologies, and Paradoxes. N.Y.: Nor-ton, 1967, p.98-с үз.

«уураг тархи» буюу «оюун ухаан» гэгдэх төрийн мэдэлд хамаатай хэмээх үзэл нийгэмд орчигч мэдээнүүд мэдээллээр баян байж, хялбархан тайлагдаж байвал нийгэм оршин тогтнож, хөгждөг гэсэн урвуу зарчим хүчирхэгжихийн хэрээр улам бүр үеэ өнгөрөөнө³¹.

Тэрээр шинжлэх ухааны мэдлэг хуримтлагддагт эргэлзээгүй хэдий ч түүгээр бүх мэдлэгийг төлөөлүүлэх боломжгүйг илтгэн, нарратив гэж нэрлэгдэх мэдлэгийн өөр төрөлтэй өрсөлдөж, зөрчилдөж, гүйцээлт болж оршдогийг үзүүлсэн. Ингэснээрээ нарратив мэдлэгийг шинжлэх ухаанаас давуу гэж хэлэх гээгүй, харин дотоод тэнцвэр, нийцлийн³² санаатай уялддаг нарратив мэдлэгийн загвартай харьцуулахад орчин үеийн шинжлэх ухааны мэдлэг «танин мэдэгчээс» хөндийрч, хэрэглэгчдээсээ хэт хүнийсч байгааг харуулахыг хичээсэн юм.

Шинжлэх ухааны мэдлэгийн хамгийн хэцүү асуулт түүний хуульчлалтай, цаашлаад нийгмийн эмх цэгцгийг хуульчлах улстөрийн асуудалтай холбогдох бөгөөд цахим эринд мэдлэгийн тухай асуудал өмнө байснаасаа илүүгээр эрх мэдлийн тухай асуудал болж байгааг тэрээр сануулжээ. Тиймээс мэдлэг, эрх мэдэл хоёр нь юуг мэдлэг гэхийг хэн шийдэх, юуг шийдэх ёстойг хэн мэдэх вэ? гэсэн нэг л асуултын хоёр тал болон илэрч байна.

Гэхдээ эдгээр асуудлыг тэрээр хэлний тоглоомын аргазүйгээр шийдсэн юм. Түүний жишээлэн үзүүлсэнээр «Их сургууль өвчилжээ» гэх мэтийн денотатив хэллэг³³, «Их сургууль нээгдлээ» гэх маягийн перформатив³⁴ хэллэг, «Их сургуульд хөрөнгө гаргаж өг» гэх зэрэг прескриптив хэллэгийн үр нөлөө, хэрэглээ нь ялгаатай төдийгүй энэ байдал асуулт, амлалт, урансайхны бичлэг, өгүүлэмж гэх мэт хэлний тоглоомын бүрдэл тус бүрт мөн адил байна. Ингэхлээр үнэний шалгуурт таардаг, денотатив хэллэгийг онцолдог шинжлэх ухааны мэдлэгээр хэлний бүх тоглоомыг төлөөлүүлж болохгүй. Гэхдээ хэлний тоглоомын талаар дараах гурван зүйлийг тооцох учиртайг Ж.Лиотар анхааруулдаг. Нэгд, дүрэм нь өөрөө хуульчлалаа агуулдаггүй ч тоглогчдын хооронд илэрхий эсвэл илэрхий бус зөвшилцсөн зүйл байдаг (гэхдээ энэ нь тоглогчид дүрмээ санаасаа зохиодог гэсэн үг биш). Хоёрт, хэрэв дүрэм байхгүй бол тоглоом ч байхгүй³⁵; дүрмийн багахан өөрчлөлт ч тоглоомын мөн чанарыг алдагдуулдаг, харин дүрмийг биелүүлээгүй «нүүдэл» буюу хэллэг түүгээр тодорхойлогдогч тоглоомд хамаагүй. Гуравт, зөвхөн юу хэлэгдсэнээр л

³¹ Jean-Francois Lyotard. The Postmodern Condition: A Report on Knowledge. University of Minnesota Press, USA, 1984 p.5.

³² "Conviviality" хэмээх нэр томъёог Иван Илич эргэлтэнд оруулжээ. Illich I. Tools for Conviviality. N.Y.: Harper & Row, 1973.

³³ Денотаци нь энд логикийн сонгодог хэрэглээн дэх дескриптивтэй тохирч байна. Куайн денотатыг true of (...н үнэн) гэдгээр солидог. А.Остин "дескриптив", "констатив" зэрэг нэр томъёог илүүд үздэг.

³⁴ Хэлний онолд Остиноос эхлэн "перформатив" нь чанд утгатай болсон.

³⁵ Neumann J., von, Morgenstern O. Theory of Games and Economic Behavior. Princeton U.P., 1948, 3 ed., 1954. P.49:

"Тоглоом бол өөрийг нь тодорхойлж буй дүрмүүдийн цогц юм". Витгенштейнийнхээр тоглоом гэдэг ойлголт нэг тодорхойлолтоор илэрхийлэгдэхгүй, учир нь уг тодорхойлолт өөрөө хэлний өвөрмөц тоглоом байдаг.

ойлгогдоно; хэллэг бүр тоглоом дахь «нүүдэл» шигээр төсөөлөгдөх ёстой.

Мэдлэгтэй холбогдуулан Лиотар мэдлэг илрэх талбар болсон нийгмийн мөн чанарыг орчин үеийн ба орчин үежсэний дараах гэсэн хос хувилбараар задлан шинжлээд эдүгээгийн нийгэмд хүн бүхэн хэзээ ч байгаагүй ээдрээтэй, өөрчлөгдөмтгий харилцаанд орж, хөгшин залуу, эрэгтэй эмэгтэй, баян ядуу гэлтгүй харилцаа холбооны өвөрмөц эргэлтийн өчүүхэн боловч «зангилаа цэг»³⁶ дээр байрлаж байгааг харуулсан. Хамгийн азгүй нь ч түүнийг дайран өнгөрөх, түүнийг илгээгч, хүлээн авагч эсвэл референтийн байранд байрлуулах мэдээнүүдийг эзэмших мэдлээ хэзээ ч бүрэн алдахгүй ийм эрин үе ирж байгааг зөгнөсөн.

Тэрээр мэдлэгийг шинжлэх ухаантай, ялангуяа түүний орчин үеийн хэлбэртэй адилтгахаас зайлсхийж, харин денотатив хэллэгээр хязгаарлагдахгүй яаж хийх, яаж амьдрах, яаж сонсохыг мэдэх гэсэн санааг давхар агуулсан, үнэний шалгуурын хамаарал, хэрэглээнээс давсан, үр өгөөж (техник чадвар), шударга ёс ба/эсвэл аз жаргал (ёсзүйн цэцэн ухаан), дуу, өнгөний гоё сайхан (сонсох, харах мэдрэмж) гэх мэт шалгуурын хамаарал, хэрэглээг багтаасан чадавхийн тухай асуудал хэмээн үнэлээд мэдлэгийг хэн нэгнийг «сайн» денотатив хэллэг, мөн «сайн» прескриптив хийгээд үнэлэмжит хэллэгийг хэлэх чадалтай болгож байгаа зүйл мөн гэж тодорхойлжээ.

Түүнийг аргазүйн ач холбогдол бүхий хандлагаар орчин үеийн философийн судалгааны талбарт харьцангуй тусгаар, бас ерийн биш тоглолт хийж, нарратив задлан шинжилгээний баялаг бүхэл бүтэн уламжлалыг тодорхойлсон гэж үнэлж болно. Нарративыг задлан шинжилсэн байдлыг нь дараах маягаар товчлон үзүүлье. Нарратив мэдлэг эерэг, сөрөг үлгэрлэгч буюу хүүрнэлийн баатрын амжилттай эсвэл азгүй үйл хэргээр дамжуулан оршин буй нийгмийн институтад хууль ёсны шинжийг олгох эсвэл нэгэнт тухайн үлгэр загвар тогтсон институтад нь багтах эсэхийг шууд зааж өгдөг. Тэгэхээр хүүрнэлүүд нэг талаас өөрсдийн яригдаж буй нийгэмд чадавхийн шалгууруудаа тогтоох боломж олгодог, нөгөө талаас энэ нийгмийн дотор юуг гүйцэлдүүлсэн, юуг гүйцэлдүүлж болохыг эдгээр шалгуурт тааруулан үнэлэх боломж олгодог. Нарратив хэлбэр өөрийн дотоодод хэлний янз бүрийн тоглоомыг хүлээн зөвшөөрдөгөөрөө шинжлэх ухааны мэдлэгээс ялгаатай. Жишээ нь тэнгэр, жилийн дөрвөн улирал, ургамал, амьтны аймгийг заасан денотатив хэллэгүүд; эдгээр референтийн тухайд эсвэл төрөл садан, эсрэг хүйстэн, үр хүүхэд, хөрш, харийн хүн гэх мэтийн тухайд юу хийх ёстойг үзүүлсэн деонтик хэллэг ч, жишээ нь (асуултанд хариулах, сонголт хийх зэрэг) сорилт тохиолдлуудад илрэх асуух хэллэг; мөн үнэлэх хэллэг гэх мэтийг олж болно.

Хүүрнэлийг дамжуулах нөхцөлд мэдлэг нь хэлэхүйн функциудаар огт хязгаарлагдахгүй; харин сонсохын тулд юуг хэлэх ёстойг, ярихын тулд юуг

³⁶ Энэ бол системийн онолын нэр томъёо. Ф.Нэмо "Энэ үгийн кибэрнэтик утгаар нийгмийг систем гэж төсөөлцгөөе. Эл систем нь харилцаа холбоог хуримтлуулан цуглуулж, эндээсээ түүнийг ахин хуваарилдаг уулзвар бүхий харилцаа холбооны сүлжээ юм..." гэж бичжээ.

сонсох ёстойг, хүүрнэлийн объект болохын тулд (хүүрнэлийг бодит байдлын талбар дээр) ямар дүрд тоглох ёстойг нэгэн зэрэг тодорхойлдог. Энэ төрлийн мэдлэгтэй холбоо бүхий ярих үйлүүд³⁷ нь иймд хэн ярьж байгаагаар төдийгүй түүнийг сонсогчоор, мөн яригдан буй гуравдагч этгээдээр хэрэгжинэ гэж Лиотар үзжээ. Хүүрнэх уламжлал нь тухайн нийгэмлэгийн өөртөө болон хүрээлэн буй орчинтойгоо харилцах харилцааг тогтоогч-яаж ярих, сонсох, хийхийг мэдэхүйн гурван талт чадавхийг тодорхойлдог шалгуурын уламжлал бас болдогийг сайтар харуулдаг. Иймд нийгмийн холбоог хуульчлах прагматик цогц дүрмүүд эдгээр хүүрнэлээр дамждаг билээ.

Цаг хугацаанд нөлөөлөх нарратив мэдлэгийн нөлөөгөөр хүүрнэлүүдийн референт нь өнгөрсөнд хамаарч буй мэт ч, үнэндээ өгүүлэх үйлдлээр үргэлж эдүгээчлэгдэж байдаг билээ. Харин шинжлэх ухаан мэдлэгийн прагматикт үнэн эсвэл худал байх өгүүлбэр нь тоглоомд оролцож буй илгээгч, хүлээн авагч, референт гэсэн прагматик байр тус бүрт тулгарах, хэллэгийг «шинжлэх ухааны» гэж хүлээн зөвшөөрөх нөхцлийг зохицуулдаг олон янзын дүрмийг хангах хэрэгтэй болдог.

Хэллэг үнэн, нотлогдох, няцаагдах боломжтой, хамаарах зүйлээ байгаагаар нь илэрхийлж байж шинжлэх ухааны гэж зөвшөөрөгдөх ёстой ч эдгээр шалгуурыг хангаж байгааг хэрхэн тогтоох вэ? гэсэн асуулт урган гарна. Нотолгоо, няцаалтын дүнд эрдэмтэд зөвшилцөлд хүрч болох ч зөвшилцөл бүр үнэний илэрхийлэл байж чадахгүй³⁸, гэхдээ бас хэллэгийн үнэн зөвшилцлийг төрүүлэхгүй байж чадахгүй. Нарратив мэдлэгийн прагматиктай харьцуулахад Лиотарын үзэж байгаагаар шинжлэх ухааных нь хэлний нэг тоглоомыг буюу денотативыг үлдээж, бусдыг нь хасахыг шаарддаг, энэ утгаараа нийгмийн холбоосыг хослон бүрдүүлдэг хэлний тоглоомуудаас тусдаа бүтээгддэг, илгээгчээс хэтэрхий их чадавхи шаарддаг хэрнээ хүлээн авагч, референтээс онцгой чадавх шаарддаггүй, хэлэгдэж байгаа гэдгээсээ хүчин төгөлдөр шинжийг олдоггүй, цаг хугацаанд нөлөөлөх нөлөө нь диахрон хэмнэлт шинжтэй, иймд референтэд холбогдох өмнөх хэллэгүүдтэй танилцаж, ялгаатай тохиолдолд л шинэ хэллэгийг дэвшүүлдэг зэргээрээ ялгаатай.

Шинжлэх ухааны оршихуйн зайлшгүй шинж шинжлэх ухааны бус мэдлэгийнхээс илүүгүй, гэхдээ бас дутуугүй бөгөөд өөр өөрийн өвөрмөц дүрэмтэй мэдлэгийн төрөл бүрийн хувьд нэгд нь "сайн" гэж тооцогдох «нүүдэл» санамсаргүй давхацлыг үл тооцвол нөгөөд нь тийм байх боломжгүй.

Иймд нарратив мэдлэгийн оршин байхуй, хүчин төгөлдөр шинжийг шинжлэх ухааны мэдлэгийн үүднээс шүүн хэлэлцэх боломжгүй, эсрэгээрээ мөн адил яагаад гэвэл тохирох шалгуурууд нь ялгаатай байдаг. Гэсэн атал тэдний

³⁷ Энэ нэр томъёог Сийрл гаргасан: "Ярих үйл нь яриан харилцааны анхдагч [хамгийн бага] суурь нэгж" Searl J.R. Speech Acts. Cambridge U.P., 1969; P.52. Бид үүнийг харилцаа гэхээсээ агол (тэмцэлдээн)-д илүүтэй хамааруулж байна.

³⁸ Үүнийг Р.Декарт сануулж байлаа. Түүнийхээр бол үнэнийг санал хураалтаар шийддэггүй.

хоорондын харилцаа тэгш бус хэмтэй, учир нь нарративийн зүгээс шинжлэх ухааны ийм дискурсийг нарратив соёлын бүл дэх нэг төрөл зүйл хэмээн үзэжханддаг бол шинжлэх ухааны талаас нарратив хэллэгүүдийг зэрлэг, бүдүүлэг, бүрэн боловсроогүй, хоцрогдсон, харийн, санаа бодлоос бүрдсэн, зан заншил, нэр хүнд, өнгөц төсөөлөл, үл мэдэхүй, үзэл суртал хэмээн өөр менталитэдэд хамааруулан ханддаг.

Гэсэн атлаа асуудлаа шийдэхийн тулд шинжлэх ухаан нарратив мэдлэгт ил, далд ямар нэг байдлаар эргэн хандаж «нээлт» хийснийхээ дараа телевизээр гарах, сонинд ярилцлага өгөхдөө эрдэмтэд мэдлэгийн тухай үлгэрийг, гэхдээ үлгэр биш үлгэрийг хүүрнэдэг. Тэд нарратив тоглоомын дүрмээр тоглодог бөгөөд үүний нөлөө нь үзэгч, уншигчдын төдийгүй эрдэмтдийн сэтгэлийн гүнд ч хүчтэй хэвээрээ байна. Энэ бол хэтрүүлэг юмуу гутаасан хэрэг огт биш, харин шинжлэх ухааны мэдлэг ба «ардын» буюу түүний орхигдуулсан тэр мэдлэг хоорондын харилцааг илэрхийлж буй юм гэж Лиотар тодруулсан байна. Төр нь шинжлэх ухааныг үлгэр тууль байдалтай болоход ихээхэн хөрөнгө зарцуулдаг: үүний ачаар төр итгэлт шинжээ олж, шийдвэр гаргагчдад өөрсдөд нь хэрэгтэй олон нийтийн хүндлэлийг олоход хэрэглэгдэх энэ үлгэр тууль дээр төрийг хүндлэх хүндэтгэл суурилдаг.

Шинжлэх ухааны хэлний тоглоом хэллэгээ үнэн байлгахыг тэмүүлдэг ч үүнийг өөрийн арга хэрэгслээр хуульчлах чадалгүй болохоор нарративаас тусламж эрэх нь зайлшгүй гэдгийг төсөөлөхөд хэцүү биш юм.

Шинжлэх ухааны мэдлэг өөрийн үнэн гэдгийг өөр мэдлэгт буюу шинжлэх ухааны үүднээс бол огтхон ч мэдлэг биш байдаг хүүрнэлд хандахгүйгээр мэдэж, үзүүлж чадахгүй юм. Эндээс хуульчлагч хүүрнэлийн тухай асуудал дэвшигдэх бөгөөд шинжлэх ухааны мэдлэгийг магтан дуулж, хууль ёсны гэж үзүүлж байгаа Платоны яриа шинжлэх ухааны биш нь илэрхий агаад иймэрхүү хуульчлагч хүүрнэлүлстөрийн эсвэл философийн шинжтэй байж мэдлэг, түүний институтуудын түүхэнд чухал ач нөлөө үзүүлсэн байдаг. Эхнийх нь чөлөөлөх хүүрнэлийг, удаах нь спекулятив хүүрнэлийг өгүүлж, эдүгээгийн боловсролын тогтолцоо, цаашлаад шинжлэх ухаан, үндэстэн, төр хоорондын холбоонд нөлөөлсөн байна. Гэхдээ Лиотарын үзсэнчлэн орчин үеийн нийгэм, соёл буюу аж үйлдвэржсэний дараах нийгэм, постмодерн соёлд³⁹ мэдлэгийн хуульчлалын асуудал өөрөөр тавигдаж байна: Агуу хүүрнэл ямар ч төрлийн нэгтгэх аргыг ашигласан, спекулятив хүүрнэл байна уу, чөлөөлөх хүүрнэл байна уу гэдгээсээ үл хамааран итгэл төрүүлэх шинжээ алдсан хэмээн Лиотар дүгнэжээ.

Постмодерн эринд мэдлэг хэрэглээгээрээ үнэлэгдэх болж, түүнчлэн бүтээмжийн шалгуур мэдлэгийн гол хоёр функци болох судалгаа, сургалтанд тавигдаж байгааг тэрээр үзүүлсэн юм. Судалгаанд нотолгоог хэрхэн хийх вэ гэдэг асуулт ээдрээтэй агаад үүнийг техник хэрэгсэл ашигласанаар шийдэж

³⁹ 1 дүгээр зүүлтийг үз. Постмодерн шинжлэх ухааны зарим шинжийг Hassan I. Culture, Indeterminacy, and Immanence: Margins of the (Postmodern) Age // Humanities in Society. Vol. 1. 1978. p.51-85-д тоймлон авч үзжээ.

болдог. Гэтэл энэ нь гаралтыг (хүлээн авсан мэдээлэл эсвэл хувиргалтыг) нэмэгдүүлж, оролтыг (зарцуулах энергийг) багасга гэх бүтээмжийн зарчмыг мөрддөг тул технологи нь үндэслэгдэх шинж нь үнэн, зөв, сайхан гэх мэтэд биш, харин үр ашигт хамаарах тоглоом юм. Техник «нүүдэл» нь бусдаас илүүг хийж бас/эсвэл бусдаас багыг зарцуулж байвал «сайн». Нотолгоо бүтээх үүднээс хүний биеийн гүйцэтгэлийг төгөлдөржүүлэх тоног төхөөрөмж нэмэлт зардал шаардана. Мөнгөгүй бол нотолгоо үгүй, тэгэхээр хэллэгийг шалгах шалгалт ч үгүй, үнэн ч үгүй. Шинжлэх ухааны хэлний тоглоом хамгийн баян нь зөвдөх хамгийн их боломж бүхий баячуудын тоглоом болно. Баялаг, үр ашиг, үнэний тэгшитгэл ийн тогтсон байна гэж тэрээр үзсэн аж. Сурганы хувьд ч бүтээмжийн ижил шалгуур үйлчилж, дээд боловсролын их, дээд сургуулиуд өнөөдөр идеал биш, харин чадавхийг төлөвшүүлэх шаардлагад захирагдаж байна. «Телематикчдыг» (мэдээлэлзүйч, кибернетикч, хэл шинжээч, математикч, логикч ...) бэлтгэхтэй холбоотой бүх салбар ухаан боловсролын түүчээ болох болно.

Өмнө өгүүлсэнчлэн мэдээллийн технологиос үүдэн мэдлэг мэдээлэлзүйн хэлэнд хөрвөн уламжлалт сурган хөгжлийн хурдыг гүйцэхгүй сайндаа л ой санамжийн хэмжээний үүрэг гүйцэтгэх тул ой санамжийн сонгодог төрөл болох номын сан зэргийг багтаасан мэдээний банкуудыг оюутны гарын дор байх цахим хэрэгсэлд сурганыг даатган үлдээж болно. Үүнд сурганы ухаан тэгтлээ гутрах хэрэггүй, учир нь оюутныг ямар нэг юманд жишээлбэл, агуулгад биш юмаа гэхэд терминалуудыг хэрэглэхэд тодруулбал, асуултыг хаашаа хаяглах, мэдмээр байгаатай зүйлтэй нь аль ой санамж таарч байдгийг томъёолох гэх мэт асуулга маягийн хэлний тоглоомыг сайтар ашиглахад сургах хэрэгтэй. Энэ үүднээс мэдээлэлзүйн ялангуяа, телематикийн анхан шатны бэлтгэл гадаад хэлний өндөр мэдлэг өнөө үндсэн шаардлага болж байгаатай нэгэн адил их сургуулийн үндсэн шаардлага болох ёстой гэж Лиотар онцлон тэмдэглэсэн байна.

Постмодерн нөхцөлд сурганы хувьд «Энэ үнэн үү?» биш, харин «Энэ юунд хэрэгтэй вэ?» гэдэг нь гол асуулт байх болно. Мэдлэгийг худалдах тухайд сүүлийн асуулт нь «Энэ зарагдах уу?» гэсэн утгатай байна. Харин бүтээмжийг дээшлүүлэх тал дээр «Энэ ашиг өгөх үү?» гэсэн утгатай болдог.

Ашиглагддаг чадавхид ийн ирээдүйтэй зах зээл байна. Ийм төрлийн мэдлэгтэй хүн ажлын санал, тэрчлэн анхаарал татах бодлогын объект болох болно⁴⁰. Мэдээний банк нь хэрэглэгч бүрийн чадвараас давсан бөгөөд энэ бол постмодерн хүний хувьд судлаж, эзэмшвэл зохих «байгаль» мөн. Постмодерн мэдлэгийн ертөнцийг өгөгдөл нь зарчмын хувьд шинжээч бүрт хүртээлтэй, шинжлэх ухааны нууц гэж үгүй гэсэн утгаар бүрэн мэдээлэл бүхий тоглоомоор удирдагддаг хэмээн дүрслэж болохуйц юм.

⁴⁰ Энэ бол дэлхийн хоёрдугаар дайнаас хойш америкийн судалгааны төвүүдийн баримтлах тууштай бодлого болжээ.

Квант механик, цөмийн физикт олсон шинжлэх ухаанд оролт/гаралтын харьцаагаар тодорхойлогддог бүтээмжээр хуульчлахуйн тулгуур болсон шалтгаацлын зарчим бүрэн утгаар боломжгүйг харуулсан. Тухайн нэг системийн оролт нь тогтмол, тэрээр уламжилсан тасралтгүй функциар илэрхийлэгдэхүйц нэгэн хэвийн "замаар" замнадаг тохиолдолд гаралтыг урьдчилан зөв тааж болох юм. Гэтэл системийн оролт буюу анхны төлвийг бүрэн тодорхойлох нь бүтэхгүй төдийгүй системийн тасралтгүй, тааварлагдахуйц түүхийн тухай төсөөлөл ч эргэлзээтэй билээ. Үүнийг дан ганц микрофизикт хамаатай гэж болох ч орчин үеийн математикт тодорхой хэмжилтийн боломжийг эргэлзээнд оруулсан урсгал бас бий. Шалтгаацсан үзэгдлүүдэд тасалдал хэлбэр төдий, санамсаргүй байдлаар хэрхэн илэрч болдогыг тодорхойлох математик хэлийг Р.Том зохиосон. Энэ хэл сүйрлийн онол гэгчийг бүтээсэн юм. «Үйл явдлын тодорхой нэг байдал их бага ямар нэг хэмжээнд энэ үйл явдлын хэсэг тус бүрийн төлөвөөр тодорхойлогддог». Шалтгаацал нь хэсгийн төлөв байдлаас өөрөө шалтгаацдаг. Байгаль ямар ч тохиолдолд хэсэг тус бүрийн анхны өгөгдөлтэй юутай ч таардаг хэсэг тус бүрийн ээдрээтэй морфологиор илэрдэг. Иймд оршин буй бүхэн «шалтгаацлын жижиг жижиг арлууд» мөн.

Ийнхүү эрдэмтдийн өгүүлж буй бүхэн үлгэр хүүрнэгчийн өгүүлж буй зүйлтэй дүйцэхээр болно хэмээн Лиотар үзээд, эрдэмтэн бол юу юунаас урьдаар «үлгэр өгүүлдэг» хүн юм, гагц ялгаа нь тэрээр үүнийгээ даруй нотлох үүрэгтэйд л оршино⁴¹ гэжээ. Судалгааныхаа эхнээс л тэрээр хэлний янз бүрийн тоглоомын формаль төдийгүй прагматик ялгааг онцлон тэмдэглэж, денотатив хэллэгүүдийг хэлэлцэх нь дүрэм сахихыг шаарддагийг үзүүлсэн. Гэтэл дүрмүүд денотатив биш, харин метапрескрипци гэж нэрлэвэл зохих прескриптив хэллэгүүд байдаг. Эдгээрийг хүлээн зөвшөөрөх цорын ганц үндэслэл нь тэд шинэ санаа өөрөөр хэлбэл шинэ хэллэг төрүүлэх бололцоо өгдөг гэдэгт оршино.

Хэлний бүх тоглоомын хувьд түгээмлээр хэрэглэгддэг метапрескрипциудын талаар ярилцагчид хэлэлцээнд хүрч болно, гэхдээ эдгээр тоглоом нь адил биш бүтэцтэй, адил биш прагматик дүрмүүдийг илтгэдэг гэдэг нь илэрхий бөгөөд ярилцлагын зорилго нь зөвшилцөл гэж ойлгогдож байгаа ч зөвшилцөл бол маргааны нэг л төлөв болохоос төгсгөл биш юм. Түүний төгсгөл бол паралоги л мөн байх учиртай. Яагаад гэвэл шинэ нь зөвшилцөлөөс биш санал зөрөлдөөнөөс ямагт төрдөг. Гэхдээ постмодерн мэдлэг нь эрх мэдлийн хэрэгсэл төдийхөн биш. Тэр нь ялгааг мэдрэх мэдрэмжийг маань хурцлахын хамт харилцан үл нийцэх байдлыг хүлцэх чадварыг маань нэмэгдүүлнэ. Тэгэхээр түүний зарчим нь шинжээчдийн гомологи бус, харин шинийг нээгчдийн паралоги юм гэж үзсэнээр Ж.Лиотар манай иргэншил дэх мэдлэгийн ирээдүйг чадамгай урьдчилан харж чадсан юм.

⁴¹ Medavar P.B. The Art of the Soluble. London: Methuen, 6 ed., 1967. Chap. "Two Conceptions of Science", "Hypothesis and Imagination".

SUMMARY

Reviewing a vast body of material on contemporary science and knowledge, Jean-Francois Lyotard has sketched the outline of the perspective of knowledge in postmodern condition. The nature of knowledge has been showed from a different point of view through narrative analysis. Drawing a parallel between science and nonscientific (narrative) knowledge in Lyotard's philosophical view helps us understand that the former's existence is no more -and no less- necessary than the latter's. He has predicted how criterion of performativity gets important and that it is significant to prefer paralogy to consensus in postmodern age.

Ном зүй

1. Austin J.L. *How to Do Things with Words*. Oxford, 1962
2. Bell D. *The Coming of Post-Industrial Society*. New York, 1973.
3. Benamou M & Caramello Ch. (ed.) *Performance in Post Modern Culture*. Wisconsin : Center for XXth Century Studies & Coda Press, 1977.
4. Hassan I. *Culture, Indeterminacy, and Immanence: Margins of the (Postmodern) Age // Humanities in Society*. Vol. 1. 1978
5. Hassan I. *The Dismembrement of Orpheus : Toward a Post Modern Literature*. New York : Oxford U.P., 1971.
6. Illich I. *Tools for Conviviality*. N.Y.: Harper & Row, 1973.
7. Jean-Francois Lyotard *The Postmodern Condition: A Report on Knowledge*. University of Minnesota Press, USA, 1984.
8. Medavari P.B. *The Art of the Soluble*. London: Methuen, 6 ed., 1967
9. Neumann J., von, Morgenstern O. *Theory of Games and Economic Behavior*. Princeton U.P., 1954
10. Watzlawick P., Helmick-Beavin J., Jackson D. *Pragmatics of Human Communication. A Study of International Patterns, Pathologies, and Paradoxes*. N.Y.: Norton, 1967